

ҮНДСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, ТӨРИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Ч.ӨЛЗИЙСАЙХАН

Доктор, дэд профессор,

МУИС. Улс төр судлалын тэнхимийн багш

Ш.ГАНХУЯГ

Доктор, дэд профессор МУИС. Философи,

шашиг судлалын тэнхимийн багш

Түлхүүр үг: Төрийн тогтолцоо, хоёр танхимтай парламент, нэг танхимтай парламент, төрийн шийдвэр гаргах үйл явцын гажуудал, ард нийтийн санал асуулга

Хураангуй: Өнөөгийн улс төрийн тогтолцоо өмнөө тавьсан зорилгоо биелүүлж чадсан уу, биелүүлэх нөөц боломж хэр зэрэг байна вэ, нийгэм эдийн засгийн өнөөгийн гажуудсан байдлыг өөрчлөх хэрэгцээ байгаа бол юуг хамгийн түрүүнд засч өөрчлөх хэрэгтэй вэ, өнөөгийн улс төрийн тогтолцооны гажуудал нь улс орны хувь заяанд ямар хор уршиг дагуулж байна вэ гэсэн асуудлуудыг энэхүү өгүүлэлд тусгасан болно.

**Өнөөгийн улс төрийн тогтолцоо өмнөө тавьсан зорилгоо биелүүлж чадсан уу,
биелүүлэх нөөц боломж хэр зэрэг байна вэ?**

Төр засгийн бүтэцдээ парламентыг оруулсан аль ч улсыг аваад үзсэн сонгуульт төлөөллийн хууль тогтоох байгууллага нь ард иргэдийн хүсэл зоригийг биелүүлэх учир шалтгаанаар л гарч ирсэн байдаг. Ард түмний хүсэл сонирхол бол шударга ёс, тэгш эрх, аз жаргалтай амьдрал байх бөгөөд улс үндэстэн бүр өөрийн гол баримт бичгүүд, тухайлбал, үндсэн хуулиуддаа энэ чин хүслийг тодорхой зааж улс төрийн системийг бүхэлд нь үүнд чиглүүлэхээр хуульчилсан байдаг. Жишээ нь Монгол Улсын Үндсэн хуулинд “хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулахаар”, Бүгд Найрамдах Польш Улсын үндсэн хуулинд “бүх иргэдийн хамтын сайн сайхны төлөө, нийгмийн шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэгч, эрх зүйт ардчилсан улс байхыг”, Франц Улсын Үндсэн хуулинд “эрх чөлөө, тэгш эрх, ах дүүгийн ёсны бүх нийтийн зорилгод үндэслэн ардчилсан хөгжлийг уриалсан” байх жишээтэй. Тэгэхээр ард түмний хүсэл зоригийг биелүүлэх учир шалтгаанаар гарч ирсэн парламентуудын нэн тэргүүний зорилго нь улс орныг сайн сайханд хүргэхээр удирдан чиглүүлэх, энэ зорилгод тохирох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх явдал л байдаг. Гэхдээ сайн сайхан зорилгуудыг тавьсан ч гэсэн улс бүр энэ зорилгодоо хүрч чаддаггүй. Өөрөөр хэлбэл, ард түмнээрээ сонгогдон гарч ирсэн л бол парламент үүргээ баттай биелүүлдэг гэж үзэх нь дэндүү хялбарчилсан дүгнэлт болно. Роберт Даль “Ардчилсан зорилго, зарчмуудыг олон тооны хүмүүс зөвшөөрөн хүлээсэн байлаа ч гэсэн цаашдын ардчилахуйн үйл явц нь үүнээс өөр нөхцөлүүдийг шаардсаар байдаг” гэж бичжээ.¹ Тухайлбал, улс төр судлаач Ё.Довчин “ардчилалд шилжих, ардчилал бэхжих үйл явц нь ялгаатай гэж үзээд ардчиллын бэхжилтэнд хэд хэдэн нөхцөл зайлшгүй бүрдсэн байх ёстой гэж үзсэний дотор “гүйцэтгэх засаглал нь

- үндсэн хуулиндаа халддаггүй
- хувь хүн, цөөнхийн эрхийг хягаж хавчдаггүй
- хууль тогтоох засаглалын ажил хэрэгт хөндлөнгөөс оролцдоггүй

болоогүй цагт нэг ч дэглэмийг ардчилсан гэж хэлэх аргагүй”² гэж бичжээ. Үүнээс өөр нэмэлт хэд хэдэн нөхцөлүүдийг заасан боловч сэдэвт шууд хамааралгүй тул орхисон болно. Энэ шалгуураар авч үзвэл Монгол Улсад ардчилал байна уу, Үндсэн хуулиар тунхагласан зорилгыг биелүүлэхэд төрийн байгуулал маань зохицож байна уу гэвэл ихээхэн өөр хариулт байх нь эргэлзээгүй. Хэдхэн хоногийн сонгуулийн кампанит ажлыг амжилттай зохион байгуулснаар гарч ирсэн нь тухайн төрийг ардчилал, шударга ёсны баталгаа гэж үнэлэхэд хангалттай үндэслэл болохгүй.

1990 оны 5-р сард “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль” гэдэг хоёр бүлэг, 22 зүйлтэй хууль гарсан бөгөөд үүгээр Монгол Улсын засаг төрийн шинэ тогтолцооны үндсийг тодорхойлсон байдаг. Тухайлбал, байнгын ажиллагаатай парламенттай, танхимын Засгийн газартай, Үндсэн хуулийн хяналтын

¹ Роберт Даль. Ардчиллын тухай. УБ., 1998, 26 дахь тал.

² Ё.Довчин. Харьцуулсан улс төр. УБ., 2006, 181 дэх тал

байгууллагатай болох зэрэг зарчмын асуудлыг шийдсэн¹. 1992 онд батлан гаргасан Үндсэн хуулиар энэ зарчмын асуудал бодит зүйл болсон. Гэхдээ орчин үеийн дэлхийн улс орнуудын төр засгийн дүр төрх бүхий төрийн байгуулалтай болох нэг хэрэг харин тэр нь ард түмний эрх ашигт нийцсэн бодлого шийдвэр гаргах нөөц бололцоог хэр зэрэг өөртөө агуулж байна вэ гэдэг ихээхэн өөр хэрэг юм. Хэлбэр нь агуулгатайгаа заавал тохирох албагүй.

Тэгэхээр бид хамгийн түрүүнд шалган магадлах зүйл маань 1992 онд баталсан Үндсэн хууль ямар зорилгыг тавиад хэрхэн биелүүлсэн бэ гэдэг асуудал. 1992 оны үндсэн хуулиар 1960 оны үндсэн хуулийн олон чухал үзэл баримтлалыг өөрчилсөн. Гэхдээ ингэж өөрчиллөө гээд бүх зүйл сайжирсан гэж үзэж болохгүй юм. 1960 оны үндсэн хуулийн социалист маягийн гэж шүүмжлэгддэг зүйлүүдийг жишээ нь, ажилчин анги тэргүүлнэ, нэг намын удирдан чиглүүлэх үүрэгтэй гэх мэт заалтуудыг алга болгосон. Гэхдээ ажилчин анги тэргүүлнэ гэсэн ч, тэргүүлэхгүй гэсэн ч тэр нь нэг их чухал нийгмийг сүйрүүлэх заалт биш, энэ бол үзэл суртлын л шинжтэй заалт байсан. Ажилчин анги биш гээд гадуурхагдаад зовоод байсан зүйлгүй л ажиллаж амьдарч байсан. Харин нэг нам биш олон намын тогтолцоо байна гэж хуульчилж заачихаад нэг нам нь засгийн эрхэнд гарахаараа нөгөө намын гэсэн бүхнийг ажлаас халах, ялгаварлан гадуурхах үзэгдлүүд өнөө цаг үед харин хэрээс хэтэрч байгаа билээ. Үндсэн хуулийг сахин хамгаалах ёстой цэц хүртэл үүнд аль нэг намын байр сууринаас хандаж нэг асуудал дээр өөр өөрөөр хариулт өгч байгаа нь нэг намын эсвэл нэг ангийн гэсэн заалтаасаа ч илүү хор уршигтай байж мэдэх үр дагаваруудыг авчирч байна.

1992 оны үндсэн хууль эдийн засгийн асуудлуудыг хэрхэн томъёолж чиглүүлсэн бэ? “Шинэ Үндсэн хууль бол ... онолын томъёоллын хувьд либераль ардчилсан үндсэн хууль гэж болно. Үүнийг уг хуулийн үндсэн үзэл баримтлалаар нотлож болно”² гэж Б.Чимэд дүгнэн бичжээ. Үнэхээр 1992 оноос хойш явуулсан эдийн засгийн бодлого бүхэлдээ либералчлах чиглэлээр явагдсан нь үнэн юм. Гэтэл улс орнуудын түүхийг авч үзэхэд аль ч улс өөрийн орны эдийн засгийг хамгаалах чиглэлд явахыг гол болгодог болохоос сул дорой эдийн засагтай байж хүчирхэг орнуудтай чөлөөтэй өрсөлдөхөөр бодлого явуулдаггүй. Жишээ нь, либерализмын гол төлөөлөгч Людвиг фон Мизес улс орнууд либерал бодлогыг ер баримтладаггүй болохыг тодорхой жишээгээр бичжээ. Тэрээр “европын улсууд капитал илүү ашиг өгч болох колони олж авах, нөгөө талд иргэдээ хамгаалахын тулд, дотоодын үйлдвэрээ хамгаалахын тулд импортын тарифыг өөрөөр тогтоож ингэснээрээ цагаачлан гарах хэрэгцээгүй болгох гэсэн оролдлого хийж байна... Англи Итали, Франц, Бельги гэх мэт Европын орнууд ... өөрсдийгөө хамгаалсан экспортын зах зээл бий болгох гэсэн. Өөрсдийнх нь хангалтгүй байсан иймээс бусдынх руугаа өнгөлзөх болсон. Чөлөөт худалдааны эх орон Англид хүртэл өнөөг хүртэл Протекционист бодлого зонхилж байна. Жил тутам энэ нь өргөжиж байна. Гадаадад бага зардлаар бий болсон бараанд үнийн зөрүүтэй нь адил болгосон тариф нэмж тогтоох нь АНУ-ын гадаад бодлогын гол үзэл суртал болж байна. Улс бүр импортоо хорогдуулах, экспортоо нэмэгдүүлэхийг хүсч байна”³ гэж бичиж байжээ.

Гэтэл манай улс өөрсдөө өрсөлдөх чадвар маш муу байж шууд либерал үзэл баримтлалтай хууль баталсан явдал нь олон улсын эдийн засгийн өрсөлдөөнд улс орноо урсгалаар нь зөнд нь орхисон, өрсөлдөөнд нэгэнт ялагдах хөрс суурийг нь бэлдэж өгсөн билээ. Чөлөөт өрсөлдөөн бүхнийг зохицуулна, төр бизнест оролцох хэрэггүй гэсэн гэнэн үзэл нь алс хэтийн ирээдүйгээ дэндүү дутуу харсан учраас ийм замыг нээсэн, одоо ч улс төрд нөлөө бүхий байгаа хүмүүс зүй нь алдааг засахад түүчээлэн явах ёстой, бас үүрэгтэй болов уу гэж бодно.

“Үзэл баримтлал гэдэг Үндсэн хуулийг боловсруулж батлахдаа, цаасан дээр бичиж томъёолохдоо удирдлага болгосон тэр үзлийг хэлж байгаа юм. Хуулийг гарсан хойно нь гуйвуулж тайлбарлаж байгааг үзэл баримтлал гэхгүй. Анх хууль батлах үед ямар үзэл баримтласан юм бэ гэдгийг тэр үеийнх нь эх сурвалжаас судлахгүйгээр тааж тайлбарлаж байгааг үзэл баримтлал гэж ойлговол алдаанд хүрнэ”⁴ гэж Б.Чимид бичжээ. Энд нэг зөрчил гарч ирнэ. Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах гэсэн сайхан зорилго тавьсан боловч түүнийг хэрэгжүүлэх механизм, хэрэгжүүлэх субъектээ бий болгохдоо алдаа гаргасан бол тэр зорилго хэзээ ч биелэхгүй юм. Сайхан зүйлийг үзэл баримтлалаа болгочихсон байсан ч гэсэн тэр үзэл баримтлалаа хамгаалах нөхцөлийг сайн тооцоогүй бол ямар ч үзэл баримтлал түүх болоод л архивт үлдэхээс биш хэн ч түүнийг баримтлах гэж явахгүй, ашиг сонирхлоороо л асуудалд хандах болдог гэдгийг өнөөдрийн Монгол Улсын байдал тодорхой харуулж байна. Дангаараа ноёрхож байсан социалист өмчийг халж нэгэнт устсан гэж байсан хувийн өмчтэй болох боломжийг нээж нийтийн болон хувийн гэсэн хоёр өмчийн хэлбэр дээр суурилсан шударга өрсөлдөг, зах зээлийн эдийн засагтай болох эрх зүйн үндсийг бий болгосон гэж сурталчилдаг. Харин бодит амьдрал дээр эрх зүйн үндсийг бий болгосон ч шударга өрсөлдөх, эрх мэдлээ буруугаар ашиглахыг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн механизмыг бий болгож чадаагүй учраас нийтийн

¹ Б.Чимид. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Пдэвтэр. УБ, 2008, 176 дахь тал.

² Б.Чимид. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Пдэвтэр. УБ, 2008, 177 дахь тал.

³ Людвиг фон Мизес. Либерализм. УБ., 2006, х.133

⁴ Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Пдэвтэр. УБ, 2008, 177 дахь тал.

баялаг эзэнгүйдэж асар их баялаг хүйтэн цэвдэг сэтгэлтний олз болон хүнийсчээ.

Хүний эрх, эрх чөлөөг бүхэл бүтэн цогц байдлаар хүлээн зөвшөөрсөн гэж байгаа боловч нийтийн баялгийг завшсан этгээдүүд баялгаа алдсан нийгмийн асар олонхийн эрх ашгийг зөрчих бүхий л талын боломжийг олж авсан тул мөн л хүний эрх, эрх чөлөөний асуудал нь цаасан дээр тунхагласан зүйл болж амьдрал дээр туйлын шударга бус, тэгш бус харилцаа ноёрхох болсон байна. Үүнийг нийгэмд байнга үүсч байдаг иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудын тэмцэл хөдөлгөөнүүд нотлон харуулж байдаг. Тухайлбал, “Амлалт нэхэн ард түмний хөдөлгөөн”, Оффшор данстай улс төрчдийг монгол төрөөр шалгуулах ард түмний онц түр зөвлөл”, “Шударга шүүхийн төлөө” ТББ гэх мэт олон байгууллагууд үйл ажиллагаагаа идэвхитэй явуулсаар байна.

Улс төрийн харилцааны хувьд олон ургальч үзэл, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч, парламентад ёс, сонгуулиар гарч ирэх төрийг улс орны удирдлагын гол үндэс болгон авч үзсэн. Гэхдээ энд дэлхийн улс орнуудын төрийн байгуулалтын хэлбэрийн талыг их анхаарсан болохоос шийдвэр гаргах үйл явц, улс төр, эдийн засгийн асар их эрх мэдэл хяналт муутай үед ямар их аюул дагуулж болохыг дутуу харсан байдаг. Мөн хүмүүсийг социалист нийгмийн үеийн сахилгатай, хариуцлагатай, айж эмээх сэтгэлтэй хэвээрээ байх юм шиг төсөөлөн бодож төр, нийгэм, иргэний харилцааг зохицуулахаар оролдож 1992 оны үндсэн хуулийг зохиож баталсан нь улс оронд асар их хүндрэлийг дагуулжээ.

Нийгмийн харилцааны хувьд ажилчин анги манлайлах, хоршоолсон ард, хөдөлмөрийн сэхээтэн ажилчин ангийн удирдлага дор шинэ нийгмийг байгуулах гэж томъёолсон байсныг өөрчилж анги, давхараа ялгалгүйгээр тэгш эрхтэй ард түмэн нийгмийн үндэс гэж гэнэн өнгөцхөн байдлаар томъёолсон. Нийтийн өмчинд ухаалаг бодлого явуулснаар тэгш эрхтэй, хангалуун амьдралтай нийгмийн олонхийг бүрдүүлнэ, ингэж чадаагүй нөхцөлд нийгмийн ялгарал эрчимтэй явагдаж, тэр нь шийдвэрлэхэд хүнд асуудлуудыг ар араасаа дагуулна гэдгийг дутуу тооцжээ. Улс төрийн харилцаагаа бодлого муутай зохицуулсан учраас ажилчин, малчин, сэхээтэн гэж ялгасан ч хоорондоо зөрчилгүй амьдарч байсан ард түмэн харин өнөөдөр өмч хөрөнгийн ялгаа, нам, бүлгээрээ ялгаварлан гадуурхагдсан шинэ түвэгтэй харилцааг бий болгож байна. Аль нэг улс төрийн нам сонгуульд ялж гарч ирснээс болоод төрийн албан хаагчид маш олноороо халагдаж солигддог, төрийн албаны мэргэшсэн байдал алдагддаг хүнд сорилтой тулгарч байна.

Үзэл санааны хувьд социалист үзэл суртлыг оюун санааны үндэс болгон үздэг байсныг өөрчилж олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрсөн. Социалист үзэл суртлыг дагалдан гарч ирдэг байсан хариуцлага, нийгмийн сайн сайхны төлөө бага балчраасаа эхлэн анхаарах хүмүүжил, үнэнч шударга хөдөлмөрлөх шаардлага, ёс суртахуунтай байх зэрэг нийгмийн харилцаанд асар их ач холбогдол бүхий зүйлүүд ямар ч хяналтгүй, дэмжлэг, шаардлагагүй болж алга болжээ. Энэ утгаараа нийгмийн оюун санааны амьдрал ихээхэн хохирол амссан байна.

Энэ үндэслэлүүдтэй эсрэг байр суурьтай иргэд, судлаачид, эрх мэдэлтнүүд олон байх нь эргэлзээгүй. Тэд одоогийн ололт амжилтууд гэж олон зүйлийг дурдаж чадна. Хүмүүс хашааныхаа газрыг өмчилж авсан, орон сууцаа өмчилж авсан, гудамжаар багтахгүй машинтай болсон, дэлхийн хаана ч ажиллаж амьдрах боломжтой болсон гэх мэт. Энэ бүх зүйлүүд үнэн боловч, иргэд хашаагаа өмчлөөгүй байсан социализмын үед тэр хашаандаа дарамттай амьдардаг байсан уу, орон сууц нь тэр хүний өмчлөлд биш эзэмшилд байлаа гээд ямар нэг хүндрэл байсан уу, төр нийтийн баялгаасаа хуваарилж машинтай болгосон уу, эсвэл өөрөө нойр хоолоо хасан хөдөлмөрлөсний хүчинд машинтай болсон уу, дэлхийн хаана ч амьдрах боломжтой боллоо гээд очоод амьдарч байгаа газраа нүүр бардам сэтгэл хангалуун баян орны иргэн шиг амьдарч ажилладаг уу, эсвэл улсаа амьдрахад хүнд байгаагаа нөхөх гэж хүний газар ажиллаж амьдарч байна уу гээд олон асуудал гарч ирнэ.

Хэрэв дээрх асуултын хариултанд сайхан ирээдүй, итгэл төгс хариулт байгаа бол бидний явсан зам мөр зөв байжээ гэж үзэх ёстой. Харин эсрэгээрээ хариултууд гарч ирээд үүнийг хэрхэн, хэзээ засах нь сураггүй байгаа бол бид өнгөрсөн зам мөрөө эргэн нягтлах, алдаа байгаа бол засахаас нааш энэ байдал өөрчлөгдөхгүй. Тэгвэл энэ өөрчлөлтийг төрийн байгуулалт, үндсэн хуультай холбон авч үзэхээс өөр арга байхгүй юм. Үндсэн хуулийн өөрчлөлтийг эсэргүүцдэг хүмүүс нийгэмд олон бий. Жишээлбэл, Үндсэн хуулийг боловсруулсан Улсын Бага Хурлын гишүүд, Үндсэн хуулийг баталсан АИХ-ын депутат, энэ хуулийн зохицуулалтаас эрх мэдэл, эд баялгаа арвижуулж бэхжүүлсэн хүмүүс, эсвэл нийгмийг дэндүү их өөрчлөх нь сайн үр дүнд хүрэхгүй гэж болгоомжилж хаширласан хэсэг, эсвэл асуудлыг ихээхэн өнгөцхөн харж буй хүмүүс энэ бүлэгт хамаарна. Нэгэнт үндсэн хуульд өөрчлөлт оруулахгүйгээр сайн сайхан байдалд хүрэх боломжгүй гэж үзэж байгаа судлаачдын хувьд бид үүнийгээ нотлох ёстой. Энэхүү өгүүллийн дараагийн хэсэгт заавал өөрчлөх учир шалтгаан болж буй үндэслэлийг тайлбарлахыг оролдоё.

Нийгэм эдийн засгийн өнөөгийн гажуудсан байдлыг өөрчлөх хэрэгцээ байгаа бол юуг хамгийн түрүүнд засч өөрчлөх хэрэгтэй вэ?

Бүх зүйлийн эхэнд төрийн институтуудыг гадны нөлөөллөөс ангид байхуйц бүтэц, зохион байгуулалтыг бий болгох хэрэгтэй. Энэ институц хэрэв нөлөөнд өртөмтгий хэвээр үлдвэл тэндээс гарах ямар ч хууль, ямар ч шийдвэр ард түмэнд ашигтай байх магадлал багатай. Ялангуяа баялгийн хуваарилалттай холбоотой, үүнийг хянахтай холбоотой, дахин хянаж үзэхийг шаардах эрх зүйн харилцааг зохицуулсан хуулиуд нийт ард түмэнд ашигтайгаар шийдэгдэх магадлал бараг байхгүй. Тийм учраас төрийн институтуудыг ухаалаг, зохистой болгох ажлыг нэн түрүүнд хийх хэрэгтэй байна. Их Британы 1900 орчим гишүүдтэй 2 танхимтай парламенттай, бас хааны гарын үсгээр баталгаажиж байж хууль батлагддаг төрд авилга өгч өөрсдөд ашигтай хууль батлуулах гэдэг компаниудын хувьд огт бүтэшгүй зүйл байдаг бол манайх шиг 76 гишүүнтэй түүнийхээ талаар нь ирц бүрддэг, тэднийхээ тал нь хуулиа батлаж чаддаг, хариуцлага тооцох боломжгүй парламенттай төрөөр авилга өгөөд ашигтай шийдвэр гаргуулах нь хамаагүй амар хялбар юм. Ийм учраас ерөөсөө парламенттай болсон, тэр нь сонгуулиар гарч ирсэн гэдэг бол ард түмний төлөө ажиллах төртэй боллоо гэсэн хэрэг огт биш юм. Энэ бол хэлбэр болохоос биш агуулгын хувьд харин ч нэг угсаа залгамжлан төрийн эрх барьж буй дарангуйлагчаас ч дор төрийн бүтэц зохион байгуулалт болж таарч байгаа юм.

Манай зарим судлаачид, улс-төрчид парламентын гишүүдийн тоог хүн амын тоотой нь харьцуулаад манайх бол дундаж хэмжээнд байгаа үүнийг өөрчлөх хэрэггүй гэсэн байр суурьтай байгаа нь харагддаг. Гэтэл улсуудын парламентын гишүүдийн тоо нь хүн амын тоотой уялдсан байх ямар нэг зүй тогтол харагддаггүй. Жишээ нь, манай улс бусад улсуудын жишгээр хүн амтайгаа уялдууллаа гэвэл хэдэн гишүүнтэй байх байж вэ гэдгийг энгийн математик хэрэглэн тооцоолбол дараах байдалтай байх бөгөөд хууль тогтоох байгууллага зохистой ажиллах бүтцийг огтхон ч бий болгож чадахгүй болох нь харагдана.

№	Улсын нэр	Байнгын ба байнгын бус ажиллагаатай	Парламентын танхимын тоо	Гишүүдийн тоо	Улсын хүн ам	Хүн ам парламентын гишүүдийг нь харьцуусан жишгээр МУ-ын парламентын гишүүдийн тоог гаргавал хэд байх вэ?
1	Албани	Байнгын	1. АИХ	140	3.038.594	138
2	АНУ	Байнгын	1. Төлөөлөгчдийн танхим	435	324.720.797	5
			2. Сенат	100		
3	Бельгийн Вант улс	Байнгын	1. Төлөөлөгчдийн танхим	150	11.250.585	40
			2. Сенат	71		
4	Бразил	Байнгын	1.Төлөөлөгчдийн танхим	513	206.440.850	7
			2. Сенат	81		
5	Герман	Байнгын	1.Бундестаг	672	82.175.700	27
			2.Бундесрат	69		
6	Грек	Байнгын	1.Депутатуудын танхим	200-300	10.955.000	82
7	Израйл	Байнгын	1.Кнессет	120	8.602.000	41
8	Испани	Байнгын	1.Депутатуудын Конгресс	350	46.423.064	39
			2.Сенат	256		
9	Итали	Байнгын	1.Депутатуудын танхим	630	60.674.003	47
			2.Сенат	326		
10	Их британи	Байнгын	1.Лордын танхим	1196	60.800.000	91
			2.нийтийн танхим	651		
11	Казакстан	Байнгын	1.Сенат	64		
			2.Мажилис	77		
12	Люксембургийн вант улс	Байнгын	1.Үндэсний Ассамблей	60	576.249	312

13	Мексик	Байнгын	1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим	128 500	119.530.735	15
14	Нидерланд	Байнгын	1.Нэгдүгээр танхим 2.Хоёрдугаар танхим	75 150	17.000.059	40
15	Норвеги	Байнгын	1.Оделстингетэд Стортинг 2.Лангтингетэд Стортинг	124 41	5.252.166	94
16	ОХУ	Байнгын	1.Холбооны Зөвлөл 2.Төрийн Дум	178 450	144.221.341	13
17	ӨАБНУ	Байнгын	1.Үндэсний Ассамблей 2.Мужуудын Үндэсний зөвлөл	350-400 100	54.956.900	27
18	Польш	Байнгын	1.Сенат 2.Сейм	100 460	38.483.957	44
19	Португали	Байнгын	1.БНУ-ын Ассамблей	230	10.341.330	66
20	Сингапур	Байнгын	1.Парламент	81	5.610.000	43
21	БНАСАУ	Байнгын бус	1.АИХ		24.895.000	
22	БНСУ	Байнгын	1.Үндэсний Ассамблей	299	50.801.405	18
23	Тайландын вант улс	Байнгын	1.Төлөөлөгчдийн танхим 2.Сенат	500 200	67.959.000	30
24	Турк	Байнгын	Үндэсний дээд ассамблей	550	78.741.356	21
25	Франц	Байнгын	1.Сенат 2.Үндэсний Ассамблей	321 577	66.991.000	40
26	БНХАУ	Байнгын бус	1.БХАТИХ	3000-аас ихгүй	1.376.049.000	5
27	Чех	Байнгын	1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим	81 200	10.553.948	79
28	Шри ланк	Байнгын	1.Үндэсний Ассамблей	225	20.277.597	33
29	Япон	Байнгын	1.Төлөөлөгчдийн танхим 2.Зөвлөхүүдийн танхим	512 252	127.110.047	18

Улс орнууд парламент нь авлигад өртөхөд боломжгүй байдлаар бүрдүүлсэн л байхаас биш хүн амын тоотой уялдуулдаг гэж үзэх нийтлэг хэмжээ огт харагдахгүй байна. Үүнээс гадна тод хараар, налуу байдлаар бичсэн улсууд нь хаантай улсууд байгаа бөгөөд энэ чухал институц нь авлига авч өгөх замаар ард түмний эсрэг шийдвэр гаргах боломжийг үндсэнд нь хаасан чухал үүргийг гүйцэтгэж байдаг. “Хаан муу шийдвэр гаргаж чадахгүй” гэдэг зарчим эдгээр орнуудад үйлчилж байдаг гэж үзэж болно.

Хэрвээ төрийн байгуулалтыг боловсронгуй болгох нь түвэгтэй гэж үзвэл (уг нь тийм ч түвэгтэй асуудал байж яавч таарахгүй. Гэхдээ үүнийг солихгүй байх нь ашигтай байгаа сонирхлын бүлэг, нийгмийн давхраа нийм шалтаг хэлж тун болзошгүй) төр, засгийн гаргасан шийдвэрийг зөв буруугаар нь ялгаж, хүлээж авах, эсвэл цуцлах эрх мэдлийг жинхэнэ утгаар нь ард түмэнд шилжүүлэх хувилбарыг сонгож болох юм. Нийтийн баялгийг зувчуулан завших боломж нээсэн эрх зүйтэй төр нь нэгэнт авлигыг цэцэглүүлэн хөгжүүлэх учраас төрийн, нийтийн албанд шударга, үнэнч, чадварлаг хүмүүсийг олж тавих шаардлагыг бүр мөсөн үгүй хийдэг. Харин өөрсдийн шийдвэрийг амар хялбар дагахуйц, өөрсдийн ов мэхийг гүйцэлдүүлж өгөхүйц сул дорой, чадваргүй, эсвэл барьцаанд орохуйц шалтгаантай хүмүүсийг л энэ албадад ажиллуулах нь хамгийн зохистой болж ирдэг. Энэ нь эргээд баялгийн хараал газар авч үгүйрэн доройтохын эх үндэс болж байдаг. Хэрэв сонгогдсон төлөөлөгч ард нийтийн эрх ашиг ноцтой зөрчигдөөд байгаа нь асуудлыг парламентад оруулж хууль батлуулах ажлыг хийхгүй бол, нийтийн эрх ашиг зөрчигдөөд яваад байвал хэн үүнийг өөрчилж чадах вэ. Жишээ нь стратегийн ордуудынхаа 34%-иа Монгол Улсын төр мөнгөө төлж худалдаж авч байж өмчлөх

эрхтэй болно гэдэг заалтыг хэн ч оруулж ирж засахгүй л өнөөг хүрч байна шүү дээ. Тэгэхээр ард түмэн өөрсдөө санал оруулж ирж хууль батлуулж болох хувилбарыг Үндсэн хуулиар баталгаажуулж өгөх ёстой.

Энэ хувилбар үндсэн хуулиар баталгаажвал бусад бүх зүйл жам ёсны голдиролдоо орно гэж л хэлэх байна. Энэ засвар нь хоёр янзаар хэрэгжиж болно. Нэг бол Үндсэн хуулиа өөрчилж жинхэнэ утгаараа хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг бий болгож чадах тийм төрийн институтүүдийг бий болгох хэрэгтэй, эсвэл өнөөгийн байгаа үндсэн хуулийн хүрээнд зарим нэг чухал өөрчлөлтийг оруулах ёстой. Тухайлбал төр, хууль тогтоогчид ямар ч хууль баталсан, эрх мэдэлтнүүд ямар ч гэрээ хэлэлцээр байгуулсан бай ард иргэд “ард нийтийн санал асуулгаар” түүнийг өөрчилж, хориглож, зогсоож чаддаг болох тийм өөрчлөлтийг оруулах хэрэгтэй. Хамгийн шилдэг хууль тогтоогч ямар байх талаар Аристотель 2000 гаруй жилийн өмнө юу гэж бичиж байсныг энд сануулахад илүүдэхгүй болов уу. Тэрээр “Солонь зарим нь гарамгай хууль тогтоогч гэж хэлдэг. Яагаад гэвэл тэрээр туйлширсан олигархийг устгаж өвөг дээдсийн алга болгочихсон демократыг тогтоосон. Ингэхдээ янз бүрийн төрийн байгууламжийн элементүүдийг оновчтой хольцолдуулсан гэнэ. Түүний ареопаг гэдэг нь олигархи элемент, сонгох аргаар албан тушаалд оруулах нь аристократ элемент, ардын шүүх нь демократ элемент юм. Гэвч Солон өмнө нь байсан зүйлийг өвлөн авчээ. Тухайлбал Ареопаг болон албан тушаалтныг сонгох зэрэг. Харин чухам тэрээр бүх хүн шүүгч байхуйцаар ардын шүүхийг буй болгосноороо демократыг тогтоосон юм”⁷ гэжээ. Энд Аристотель Солонь алдаршуулж буй хамгийн гол зүйл нь ард түмэн эцсийн дүнд шүүгчийг нь хийж чадах тийм тогтолцоог бий болгосон явдал, харин бусад нь бол өмнө нь байсан л тогтолцоо шүү дээ гэж өгүүлсэн болох нь харагдаж байна. Үнэхээр Үндсэн хуулийг хэвээр хадгалан үлдээхээр бол энэ зохицуулалтыг зайлшгүй бий болгож ард түмэн жинхэнэ утгаар шүүгч байх нөхцөлийг бүрдүүлэхгүйгээр юм өөрчлөгдөхгүй билээ.

Хууль батлагдан гарах процесс дэндүү хялбар, амархан байж болохгүй. Учир нь алдаатай, хийдэлтэй, эсвэл зориуд хэн нэгний талд ашигтайгаар шийдэх хэрэгтэй учраас бичигдсэн хуулийн төсөл байвал тэр нь олон шүлтүүрийг дамжиж, хянагдаж, няцаагдаж байх нөхцөлийг бүрдүүлсэн парламент байх ёстой. Дэлхийн олон улс орон 2 танхимтай парламентыг ийм зорилготойгоор бүрдүүлсэн байдаг. Цаг хугацааны хувьд хоёр танхимтай парламенттай болох гэсэн санаанууд бүр эртнээс, МЭӨ IV-III зуунаас эхтэй. Гэхдээ сонгодог парламент гэсэн утгаар Английн парламентыг жишээ болгон авч үздэг. Сонгодог гэдэг үг нь сонгож шалгарсан, хөгжлийг хангадаг, хүн бүхэнд үгүй юм гэхэд нийгмийн олонхийн эрх ашгийг хамгаалж чаддаг учраас л сонгогдоод, илүү дээр байна гэж үзэгдээд байна гэсэн утгыг илэрхийлж байдаг. Түүнээс биш Англи улс хүчирхэг учраас дуурайгаад байгаа хэрэг биш. Тэр нь худалдагдахгүй, хэд хэдэн дамжлагатай, хуулийн систем нь ойлгомжтой, эртнээсээ шударга ёсонд үндэслэсэн шүүх тогтолцоо энэ бүхэн нь шударга ёс, сонгодог гэдэг утгыг нь бий болгож байгаа юм. Түүнээс биш 2 байх ёстой гээд 76 гишүүнээ 2 хуваагаад 50:26 ч юмуу хуваарилалт хийж өөр өөр танхимд суулгаснаар бүх юм сайхан болно гэж байгаа бол асуудалд дэндүү хөнгөн гоомой хандаж байгаа хэрэг болно. Их Британий Лордын танхим нь язгууртан, хөдлөшгүй, баталгаат эдийн засгийн нөөц чадамжтай байдал нь тэднийг асуудалд тогтвортой, ухаалаг, гуйвшгүй байхыг нөхцөлдүүлж байгаа юм. Харин доод танхим нь жирийн иргэдээс гарч ирж төрийн асуудлыг шийдэх боломжийг хангасан бүтэц юм. Ийм утга агуулгыг илэрхийлж чадах парламентыг Монгол Улсын онцлогтой уялдуулан бий болгох хэрэгтэй байна.

Холбооны улс бол хоёр танхимтай, нэгдмэл улс бол нэг танхимтай гэдэг яриа бол ихээхэн буруу тайлбарлаж байгаа хэрэг юм. Лийпхарт 36 орны ардчиллыг харьцуулж судалсан судалгааныхаа ажилд “36 ардчилал дотор холбооны тогтолцоотой есөн улс хос танхимтай парламенттай ба 1996 оны байдлаар 27 нэгдмэл улсын парламент тэнцүү байдалтайгаар нэг эсвэл хос танхимтай байна. 13 нь нэг танхимтай, 13 нь хос танхимтай. Норвеги улс нэг-ба-хагас танхимын тогтолцоотой”⁸ гэж бичжээ. Тэгэхээр Монгол Улс нэгдмэл улс учраас нэг танхимтай парламенттай байх ёстой гэж үзэх нь худлаа болж байна. Хэдийгээр холбооны улс нь мужуудаа төлөөлүүлэх гэж хоёр танхимыг сонгох хандлага байдаг ч гэсэн энэ нь заавал тийм байх ёстой гэсэн үг биш. Энэ нь хууль батлах үйл явцыг хяналттай, шалгууртай, ухаалаг болгох гэсэн зорилгыг агуулж байгаа болохоос биш яг нэг штат мужийг төлөөлөх гэсэн утгыг илэрхийлдэггүй. Жишээ нь АНУ-ын сенат нь муж бүрээс 2 хүн орж мужаа төлөөлж байдаг ч гэсэн гол нь олон хүнтэй мужууд нь олноороо түрий барьж өөрсдийн талд шийдэх вий гэснээс болгоомжилж, өөрөөр хэлбэл олонхийн дарангуйллаас цөөнхийн эрх ашгийг хамгаалах гэсэн утгаараа авч үзвэл харин ч холбооны улсын сул талыг засах тэнцвэртэй шийдвэр гаргах гэсэн утгыг түлхүү илэрхийлж байдаг. Хос танхимтай хурал хууль батлахдаа уддаг гэж шүүмжлэх нь бий. Гэвч хуулийг хурдан юм уу удаан гаргах нь гол биш, харин ухаалаг гаргах нь л гол юм. Хоёр танхимд хоёулаа хүлээн зөвшөөрөхүйц асуудал заавал удаан гарах ч албагүй. Гэхдээ манайх шиг баярын өмнө, шөнө дундуур хуралдаад алх тогшчих, муу хуулийг маш хурдан шийдээд батлачих боломж үнэхээр хумигдана.

Зарим судлаачид уламжлалт легитимийн үүрэг ач холбогдол буурч байгаа гэж үзэх нь бий. Эзэн хаадтай, тэдгээр нь засаглалын эрх мэдлийг удам дамжуулан эзэмшиж байдаг улсуудад улс орны амьдрал ихэнхдээ

⁷ Аристотель. Улс төр. Орч. Б.Даш-Ёндон, УБ., 2006, 65 дахь тал.

⁸ Арэнд Лийпхард. Ардчиллын хэв загвар. Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл. Орч. Д.Ганбат. 18-21 дэх тал.

өөдлөн дэвжих магадлал ажиглагдаж байдаг бол халаа сэлгээ, тэмцэл зөрчил ихтэй улс орнуудад асуудлаа шийдэж чаддаггүй, зөв шийдэлд хүрч чаддаггүй, ард түмний эрх ашгийг хамгаалах боломжтой хэсгийнхэн улс төрийн засаглалд байр суурна олоход хамгийн түвэгтэй байдаг болох нь харагдаж байна. Удирдагчийг хаан гэнэ үү, удирдагч гэнэ үү авторитарн удирдагч гэнэ үү, дарангуйлагч гэнэ үү ялгаагүй тэр нь удирдагч л юм. Харин Гитлер, Пол пот мэтийн цоон гашуун түүхтэй удирдагчдаар нийт уламжлалт легитим, хүчирхэг удирдагчдын нэр хүндийг унагаах нь буруу зүйл юм. Харамсалтай нь энэ бол монголчууд бидэнд одоо нэгэнт боломжгүй болсон удирдлагын хэлбэр. Хүчирхэг ухаалаг уламжлалт засаглалын удирдлагын давуу талыг ерөнхийлөгч хэмээх хэдэн жил болоод ажлаа өгөөд буучихдаг хүний хийж бүтээсэн зүйлтэй харьцуулах бараг боломжгүй. Тиймээс Монгол Улсад нийт ард түмнийг дайчлан зохион байгуулах хошуучлагч үнэхээр дутагдаж байгаа билээ. Хүчтэй нийтийн эрх ашгийг зөв бодох удирдагчгүй, дээр нь төрийн тогтолцоо муу учраас төрийн зөв зүйтэй зохицуулалт, ухаалаг бодлого байхгүй болж ингэснээр хувийн хэвшлийнхэн ч үйлдвэрлээ өргөжүүлэх, хөгжүүлэх боломж нь хумигдаж, улс орны эдийн засаг жинхэнэ утгаараа хөгжиж дэвждэггүй. Ийм учраас өнөөгийн нийгэм эдийн засгийн байдлыг өөрчлөх хэрэгцээ байгаа бол юуг хамгийн түрүүнд засч өөрчлөх эдгээр асуудлыг тооцож өөрчлөлтийг хийх ёстой.

Эрх зүйт төрийг улам доройтуулж сулруулдаг энэ тогтолцоо нь баялгийг хэрхэн хэн нь хувааж авах вэ гэдэгт л эрх баригчдын анхаарлыг төвлөрүүлж хуваарилалтаас хоцрохгүй байх, хуваарилалтанд нөлөө бүхий бүлэглэлд хамрагдах гэдэгт л анхаарал хандуулахад хүргэх учраас байгалийн нөөцийн олборлолтоос өрөм хуулсан байдлаар эдийн засгаа сул орхиж түүнийг төрөлжүүлэх, алсыг харсан ухаалаг эдийн засгийн бодлого явуулах сонирхлыг нь бууруулж байдаг. Энэ нь эргээд улс орны хөгжил дэвшил, эв нэгдэл, аюулгүй байдалд ноцтой үр дагаварыг авчирна. Цуст алмазны дайн, үндэстэн хоорондын мөргөлдөөн гэх мэт олон зуун мянган хүний аминд хүрсэн иргэний дайн, мөргөлдөөнүүд нь эцсийн дүнд ийм төрийн бодлогын үр дүн байдаг. Үүнээс ч дутахгүй аюултай байдал нь улс орноо эн тэргүүнд тавих, ард түмнийхээ амин чухал эрх ашгийг бодох сэтгэл дутуу байдал нь улс орны асар их баялгийг өөр улс орнуудад хялбар хүртэх, эс бөгөөс эзлэн авах сэдлийг төрүүлж байдаг бөгөөд хэрэв энэ нь эрх баригчдад аюултай гэж үзсэн тохиолдолд нийгэм эдийн засгаа хөгжүүлэхэд зориулах ёстой асар их хөрөнгө мөнгийг батлан хамгаалах чиглэлд зарцуулахад хүрдэг байна.

Ийм учраас цөөхөн хүн амтай, байгалийн их баялагтай улс орны хувьд байгалийн баялгийг, ялангуяа стратегийн ордыг ард нийтийн санал асуулгаар шийдэж, баялгийн борлуулалтаас орж ирсэн орлогыг тусгай санд төвлөрүүлж, түүнийг хэрхэн зөв зохицуулах талаар Норвеги, Ботсвана, Сингапур зэрэг орны туршлагыг анхааралтай судлаж энэ чиглэлд ажиллах ёстой.

Улс орныг зөв зам руу оруулахын тулд үнэхээр ухаалаг зөв замыг зааж чадах улс төрийн хошуучлагч гарцаагүй чухал. Ардчиллыг дарангуйлагч гэдэг айхавтар зүйлээс айлгах арга хэрэгсэл болгон ашиглах нь түгээмэл. Гэтэл нэг хүний удирдлага маш чухал байж болохыг эзэн хаадтай улсууд, Сингапур, Өмнөд солонгос, өнөөгийн Оросын Холбооны Улс ч харуулж байна. Хүн төрөлхтөн сайн, муу удирдагчдын аль алиных нь арвин баян түүхтэй билээ. Харин муу удирдагчид улс орныг доройтуулдаг түүх бий гээд сайн удирагч, хошуучлагчийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь утгагүй юм. Харин удирдагчийн сайхан сэтгэлийн тухай асуудал гарцаагүй яригдаж таарна. Зүй бус институцтэй улс орнуудад хамгийн шилдэг тэргүүний хүмүүс ард түмний итгэлийг авч төрийн удирдлагад орж ирэх явдал ихээхэн саадтай, харин тодорхой бүлэглэлийн эрх ашгийг хамгийн үг дуугүй биелүүлэгчид удирдлагад гарч ирэх нь их учраас ард түмнийг дайчлан зохион байгуулж удирдах ёстой хүмүүс нийгэмд үүрэг гүйцэтгэж чадахгүй өнгөрөх магадал ихтэй юм.

Олон эрдэмтэн мэргэд, судлаачид, эдийн засагчид улс орныг эрүүл саруул ухаанаар бодоход ингэж шийдвэл илүү зохистой гэсэн байр сууринаас хандаж удирдах ёстойг зааж сургасан байдаг. Өөрөөр хэлбэл, улс орныг зөв удирдахад мэдлэгтэй байхаас илүү, хамгийн гол зүйл бол сайн үйл хийх чин сэтгэлтэй байх нь л чухал юм. Аристотель сайн үйлийг мэдлэгтэй адилтгасан Сократын үзлийг шүүмжилж “энэ бол байж боломгүй зүйл. Учир нь гэвээс, аливаа мэдлэг бол боломжийн урьдач нөхцөл юм. Гэтэл бодомж сэтгэл санааны сэтгэдэг хэсэгт нь үүсдэг. Ингээд бодохоор, Сократынхаар бол, бүх сайн үйл сэтгэл санааны оюун ухааны хэсэгт үүсдэг болж таарах нь Ийм учраас Сократ сайн үйлийг мэдлэгтэй адилтгасан, гэтэл энэ нь сэтгэл санаан дахь оюун ухааны гаднах хэсгийг, тэгээд түүнтэйгээ хамт хүний хүсэл шуналыг илэрхийлдэг сэтгэлийн хөдөлгөөнийг ч, улмаар зан аашийг ч сайн үйлтэй холбогдолгүй болгочихож байгаа хэрэг юм. Ийм болохоор сайн үйлийг үзэх түүний үзэл буруу юм”⁹ гэжээ. Эндээс хэрэв төрийн бүтэц нь зохисгүй байгаад дээр нь мэдлэгтэй байсан ч өөрийнхөө амин хувийн ашиг сонирхлыг ард түмнийхээс түрүүлж бодох төрийн хүмүүстэй байвал улс орон хөгжих цэцэглэх боломжгүй болно. Орчин үед, хүмүүсийн муу авир, зуршлийг хязгаарлах боломжгүй ийм төртэй улс орнуудад үйлдвэрлэл ч хөгждөггүй, улс орон нь өр зээлэндээ баригдаж, энэ нь ядуурал зовлонгийн эх үүсвэр нь болж байдаг. Нэгэнт эх оронд нь хүнд хэцүү

⁹ Аристотель, Лэлл сурталуучи УБ 2008 14 дүм төл

амьдрал, сайн сайханд хүрэх итгэл найдвар, ирээдүй, гарцгүй байдаг учраас иргэд нь цагаачлан амьдрахыг хүсч байдаг.

Энэ бүхнээс дүгнэн бодвол бидэнд шийдэх асуудлууд маш их байна. Үүнд:

Төрийн тогтолцоог өөрчлөх, боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна. Болж өгвөл өргөн бүрэлдэхүүнтэй, хоёр танхимтай, авлигад амар хялбар өртөхөөргүй бүтэцтэй парламенттай болох хэрэгтэй байна. Хэрэв төрийн тогтолцоог өөрчлөх боломж хязгаарлагдмал гэж үзвэл үндсэн хуулинд байгаа ард нийтийн санал асуулгын тухай заалтаас урган гарах органик хуулиудыг өөрчилж үндсэн хуулийн энэ заалтыг улс орны эрх ашгийн үүднээс “амьдруулах” хэрэгтэй байна. Улс төрийн шилдэг хошуучлагчид, түүнийг дэмжин ажиллах шилдэгүүдийг шалгаруулах механизм жинхэнэ утгаараа ажиллах ёстой гэх мэт асуудлуудыг шийдэж чадвал дараагийн асуудлууд хялбархан шийдэгдэх болно. Эдгээр асуудлыг шийдэж чадахгүй бол юуг ч өөрчилж сайжруулж чадахгүй, байсан байрандаа, магадгүй түүнээс ч доогуур түвшинд орж зүдэрсээр байх болно. 2016 оны УИХ-ын сонгуулиар 65 суудал авч парламентын олонхи болсон МАН түүхэн чухал үүргийг гүйцэтгэх хувь заяан дээр очиж байна. Тэд үнэхээр Монгол Улсын төлөө улс төрийн хүчин юм бол энэ өөрчлөлтийг хийх болно. Хэрэв хэсэг бүлэгхэн хүн эрх мэдлийг гартаа барьж өөрсдийн ашиг тусын тулд боломжийг ашиглахаар бодож байгаа бол юу ч өөрчлөгдөхгүй хэвээр үлдэх юм.

Abstract: The following issues were reflected in the paper - could current political system achieve its goals, are there enough resources to achieve more, how should we fix the social and economic flaws, what problems should we fix first, what happen to the problems which are not fixed?

НОМ ЗҮЙ:

1. Аристотель. Дээд суртахуун. УБ., 2008, 14 дэх тал
2. Арнд Лийпхард. Ардчиллын хэв загвар. Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл. Орч. Д.Ганбат.
3. Ё.Довчин. Харьцуулсан улс төр. УБ., 2006
4. Д.Лүндээжанцан. Эрх мэдэл ба ардчилал. УБ., 2015
5. Людвиг фон Мизес. Либерализм. УБ., 2006, х.133
6. Роберт Даль. Ардчиллын тухай. УБ., 1998
7. Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг. Ред.Ё.Довчин, УБ., 2012
8. Б.Чимид. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Идэвтэр. УБ, 2008,
9. Region as Solutions: What is the Problem? Pierre Chabal. Contemporary political Society. Winter 2015, volume 3 number 16 Special Issue The Limits of Regional cooperation.